



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар E/01

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Элчин сайд нарыг эгүүлэн татах,
томилох асуудлаар зөвшилцөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг,

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг,

3. Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзийг,

4. Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаярыг тус тус томилох асуудлыг зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

2024000007



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcot@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.01.05 № 05/330
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Сүхээгийн Сүхболд, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Гунаажавын Байгалмаа, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Цэрэндоржийн Мөнх-Өлзий, Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр томилогдохоор нэр дэвшсэн Нямдоржийн Анхбаяр нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

Хүндэтгэсэн,

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Т.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.01.05 № 31-1/04
танай _____-ны № _____-т

Санал өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбатыг томилуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлсэн саналыг, Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Дорж, Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболд нарыг тус тус эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболд, Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмаа, Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзий, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаяр нарыг тус тус томилуулах тухай саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

Холбогдох материалыг хавсаргав.

Монгол Улсын Ерөнхий сайд



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244000324

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлд:

“5.3.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсаас гадаадын зарим улсад суугаа Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох саналын тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбатыг томилуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлсэн саналыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг;

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг;

3.Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзийг;

4.Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаярыг тус тус томилуулах саналыг дэмжиж, энэ тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсаас гадаадын зарим улсад суугаа Элчин сайд нар, НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийг эгүүлэн татах, томилох саналын тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг;
2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг;
3. Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзийг;
4. Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаярыг тус тус томилуулах саналыг танилцуулж байна.

Эгүүлэн татагдаж буй Элчин сайд Б.Дорж, Т.Жанабазар, В.Энхболд нарын томилолтын хугацаа нь дууссан, Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Элчин сайд томилогдоогүй байгаа болно.

Элчин сайд, Байнгын төлөөлөгч нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа улс, олон улсын байгууллагадаа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгааг хийж, төр, засгийн байгууллагыг мэдээллээр хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, хоёр болон олон талын харилцааны асуудлаар яриа, хэлэлцээ хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладагаас гадна тэргүүлж буй Дипломат төлөөлөгчийн газрынхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг.

Элчин сайд, Байнгын төлөөлөгчөөр томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй эдгээр албан хаагчид нь төрийн болон дипломат албанд олон жил ажилласан, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршлагатай, гадаад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан, мэргэжлийн дипломатууд юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төсөл

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг тохоон томилсугай.

ГАРЫН ҮСЭГ

ЗӨВШӨӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Б.БАТЦЭЦЭГ

ТАНИЛЦУУЛГА

1. Сүхээгийн Сүхболдыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилуулахаар танилцуулж байна.

2. 1976 онд Сэлэнгэ аймгийн Хушаат суманд төрсөн.

3. 48 настай

4. Эрэгтэй

5. Гэр бүлийн байдал: Эхнэр, 4 хүүхэдтэй

6. Хэзээ, хаана ямар сургууль, дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

1999 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, 2005 онд Австрали Улсын Викториагийн Технологийн их сургуулийг тус тус төгссөн. Олон улсын эрх зүйч мэргэжилтэй, Бизнесийн удирдлагын магистр. "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" дипломат цолтой. Англи, орос хэлний мэдлэгтэй.

7. Ажилласан байдал:

1999 онд ГХЯ-ын Олон улсын байгууллагын газарт мэргэжилтэн, 1999-2007 онд Гэрээ, эрх зүйн газарт мэргэжилтэн, атташе, гуравдугаар нарийн бичгийн дарга, 2007-2010 онд Нью-Йорк дахь Байнгын төлөөлөгчийн газарт хоёрдугаар нарийн бичгийн дарга, 2010-2012 онд ГХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт дэд захирал, 2012 онд Гэрээ, эрх зүйн газарт захирлын үүрэг гүйцэтгэгч, 2012-2015 онд ГХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын захирал, 2015-2020 онд Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, 2020 оноос ГХЯ-ны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирлаар ажиллаж байна.

8. Ажилласан хугацаа (жилээр):

Төрийн албанд 23 жил

Дипломат албанд 23 жил

9. Энэ иргэнийг тухайн албан тушаалд томилуулах (чөлөөлүүлэх) үндэслэл:

Мэргэжлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршлага, гадаад хэлний мэдлэгийг харгалзан энэхүү албыг хаших бүрэн боломжтой гэж үзэж байна.

10. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан мэргэшлийн шалгалтын дүн

11. Энэ асуудлыг шийдвэрлүүлэх (хэний санал ирсэн)-ээр бэлтгэсэн

Гадаад харилцааны сайдын саналаар

12. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт

Хянасан:

Төрийн захиргааны удирдлагын газар /ТЗУГ-ын захирал

Д.Амарсайхан

Боловсруулсан: ТЗУГ-ын зөвлөх

Ш.Цэнд-Аюуш

13. Албан тушаалд томилох үед өгсөн үүрэг, зөвлөмж

2024 оны 01 дүгээр сарын 22 ны өдөр

Төсөл

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг томилсугай.

ГАРЫН ҮСЭГ

ЗӨВШӨӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Б.БАТЦЭЦЭГ

ТАНИЛЦУУЛГА

1. Гунаажавын Байгалмааг Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилуулахаар танилцуулж байна.

2. 1971 онд Улаанбаатар хотод төрсөн.

3. 53 настай

4. эмэгтэй

5. Гэр бүлийн байдал: Нөхөр, 4 хүүхэдтэй

6. Хэзээ, хаана ямар сургууль, дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

1995 онд БНХАУ-ын Уши хотын Хөнгөн үйлдвэрийн их сургуулийг төгссөн. 1998 онд Шинэ Зеланд Улсын Веллингтоны их сургууль, 2016 онд Москвагийн Олон улсын харилцааны их сургуульд олон улсын харилцаа, англи хэлний чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн. Инженер, олон улсын харилцааны мэргэжилтэй. "Тэргүүн шадар" дипломат цолтой. Англи, орос, хятад хэлний мэдлэгтэй.

7. Ажилласан байдал:

1996-2000 онд ГХЯ-ны Нэгдүгээр газарт мэргэжилтэн, 2000-2003 онд Бээжин дэх ЭСЯ-нд атташе, гуравдугаар нарийн бичгийн дарга, 2003-2005 онд ГХЯ-ны Хөрш орнуудын газарт гуравдугаар нарийн бичгийн дарга, 2005-2008 онд Бээжин дэх ЭСЯ-нд хоёрдугаар нарийн бичгийн дарга, 2008-2011 онд ГХЯ-ны Хөрш орнуудын газарт хоёрдугаар нарийн бичгийн дарга, 2011-2015 онд Бээжин дэх ЭСЯ-нд нэгдүгээр нарийн бичгийн дарга, 2015-2016 онд ГХЯ-ны Европын газарт нэгдүгээр нарийн бичгийн дарга, 2016-2018 онд Хөрш орнуудын газрын дэд захирал, 2018-2022 онд Бээжин дэх ЭСЯ-нд зөвлөх, 2022 оноос ГХЯ-ны Хөрш орнуудын газарт зөвлөх, дэд захирлаар ажиллаж байна.

8. Ажилласан хугацаа (жилээр):

Төрийн албанд 27 жил

Дипломат албанд 27 жил

9. Энэ иргэнийг тухайн албан тушаалд томилуулах (чөлөөлүүлэх) үндэслэл:

Мэргэжлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршлага, гадаад хэлний мэдлэгийг харгалзан энэхүү албыг хаших бүрэн боломжтой гэж үзэж байна.

10. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан мэргэшлийн шалгалтын дүн

11. Энэ асуудлыг шийдвэрлүүлэх (хэний санал ирсэн)-ээр бэлтгэсэн

Гадаад харилцааны сайдын саналаар

12. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт

Хянасан:

Төрийн захиргааны удирдлагын газар /ТЗУГ/-ын захирал

Д.Амарсайхан

Боловсруулсан: ТЗУГ-ын зөвлөх

Ш.Цэнд-Аюуш

13. Албан тушаалд томилох үед өгсөн үүрэг, зөвлөмж

2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр



Төсөл

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзийг томилсугай.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

1. Цэрэндоржийн Мөнх-Өлзийг Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилуулахаар танилцуулж байна.

2. 1974 онд Архангай аймгийн Цэцэрлэг суманд төрсөн.

3. 50 настай

4. Эрэгтэй

5. Гэр бүлийн байдал: Эхнэр, 3 хүүхэдтэй

6. Хэзээ, хаана ямар сургууль, дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

1999 онд АНУ-ын Үндэсний их сургууль, 2001 онд АНУ-ын Иргэний агаарын КомЭйр сургууль, 2017 онд Монгол Улсын Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуулийг тус тус төгссөн. Гадаад хэлний мэргэжилтэн, инженер мэргэжилтэй, Төрийн захиргааны удирдлагын магистр. "Тэргүүн шадар" дипломат цолтой. Англи, орос хэлний мэдлэгтэй.

7. Ажилласан байдал:

2004 онд ГХЯ-ын Ёслолын хэлтэст мэргэжилтэн, 2004-2006 онд Төрийн захиргааны удирдлагын газар атташе, 2006-2007 онд Америк, Ойрхи Дорнод, Африкийн газар атташе, 2007-2010 онд Женев дэх Байнгын төлөөлөгчийн газарт атташе, гурав, хоёрдугаар нарийн бичгийн дарга, 2010-2012 онд ГХЯ-ны Төрийн дипломат ёслолын газарт хоёрдугаар нарийн бичгийн дарга, 2012 онд Олон нийттэй харилцах газрын дэд захирал, 2012-2013 онд Төрийн дипломат ёслолын газарт нэгдүгээр нарийн бичгийн дарга, 2013-2016 онд Оттава дахь ЭСЯ-нд нэгдүгээр нарийн бичгийн дарга, зөвлөх, 2016-2018 онд Дипломат ёслолын газрын захирал, 2018-2021 онд Оттава дахь ЭСЯ-нд Элчин зөвлөх, 2021 оноос Дипломат ёслолын газрын захирлаар ажиллаж байна.

8. Ажилласан хугацаа (жилээр):

Төрийн албанд 20 жил

Дипломат албанд 20 жил

9. Энэ иргэнийг тухайн албан тушаалд томилуулах (чөлөөлүүлэх) үндэслэл:

Мэргэжлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршлага, гадаад хэлний мэдлэгийг харгалзан энэхүү албыг хаших бүрэн боломжтой гэж үзэж байна.

10. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан мэргэшлийн шалгалтын дүн

11. Энэ асуудлыг шийдвэрлүүлэх (хэний санал ирсэн)-ээр бэлтгэсэн

Гадаад харилцааны сайдын саналаар

12. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт

Хянасан:

Төрийн захиргааны удирдлагын газар /ТЗУГ/-ын захирал

Д.Амарсайхан

Боловсруулсан: ТЗУГ-ын зөвлөх

Ш.Цэнд-Аюуш

13. Албан тушаалд томилох үед өгсөн үүрэг, зөвлөмж

2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

Төсөл

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Байнгын төлөөлөгчийг эгүүлэн татах,
тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаярыг томилсугай.

ГАРЫН ҮСЭГ

ЗӨВШӨӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Б.БАТЦЭЦЭГ

ТАНИЛЦУУЛГА

1. **Нямдоржийн Анхбаярыг Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр томилуулахаар танилцуулж байна.**

2. **1979 онд Увс аймгийн Улаангом суманд төрсөн.**

3. **45 настай**

4. **Эрэгтэй**

5. Гэр бүлийн байдал: **Эхнэр, 2 хүүхэдтэй**

6. Хэзээ, хаана ямар сургууль, дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

2001 онд МУИС-ын Хууль зүйн сургууль, 2006 онд Шинэ Зеланд Улсын Веллингтоны их сургуулийг тус тус төгссөн. Хуульч мэргэжилтэй, Хууль зүйн ухааны магистр. "Тэргүүн шадар" дипломат цолтой. Англи, орос хэлний мэдлэгтэй.

7. Ажилласан байдал:

2000-2002 УИХ-ын Тамгын газрын ажлын албанд УИХ-ын гишүүний туслах, 2003-2004 онд УИХ-ын МАН-ын бүлгийн Ажлын албанд референт, 2007-2011 онд Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүйн газарт мэргэжилтэн, атташе, дэд захирал, 2011-2014 онд Монгол Улсаас АНУ-ын Сан Франциско хотод суугаа Ерөнхий консул, 2014 онд ГХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, 2014-2016 онд Олон улсын гэрээ, эрх зүйн газрын Хүний эрхийн хэлтсийн дарга, Консулын газрын дэд захирал, 2016-2020 онд Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын захирал, 2020 оноос ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

8. Ажилласан хугацаа (жилээр):

Төрийн албанд 22 жил

Дипломат албанд 17 жил

9. Энэ иргэнийг тухайн албан тушаалд томилуулах (чөлөөлүүлэх) үндэслэл:

Мэргэжлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршлага, гадаад хэлний мэдлэгийг харгалзан энэхүү албыг хаших бүрэн боломжтой гэж үзэж байна.

10. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан мэргэшлийн шалгалтын дүн

11. Энэ асуудлыг шийдвэрлүүлэх (хэний санал ирсэн)-ээр бэлтгэсэн

Гадаад харилцааны сайдын саналаар

12. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт

Хянасан: Төрийн захиргааны удирдлагын газар /ТЗУГ/-ын захирал

Д.Амарсайхан

Боловсруулсан: ТЗУГ-ын зөвлөх

Ш.Цэнд-Аюуш

13. Албан тушаалд томилох үед өгсөн үүрэг, зөвлөмж

2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

